



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

「 Сар шинийн баярт зориулсан үндэсний
Шагайн харвааны тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монголын уламжлалт Сар шинийн баяр”-т зориулсан Үндэсний шагайн харвааны насанд хүрэгчид, өсвөрийн нээлттэй тэмцээнийг дүүрэгт 2026 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулахыг Дүүргийн Шагайн харвааны салбар холбоо (Ц.Жамбалцэрэн)-нд үүрэг болгосугай.

2.Тэмцээний өсвөрийн харваачдын шагналд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталж, шаардагдах 750.000 (Долоон зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 08 -ны өдрийн
8/33 дугаар захирамжийн хавсралт



ШАГНАЛД ЗАРЦУУЛАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Медаль	Ширхэг	24	10,000	240,000
2	Өргөмжлөл	Ширхэг	3	20,000	60,000
3	1-р байр	Мөнгөн шагнал	1	200,000	200,000
4	2-р байр	Мөнгөн шагнал	1	150,000	150,000
5	3-р байр	Мөнгөн шагнал	1	100,000	100,000
Нийт					750,000